



Төрийн өмчийн хорооны 1998 оны 285 дугаар тогтоолын хавсралт

ТӨрийн ӨмЧийн оролцоотой хЯзгаарлагдмал хариуцлагатай компанийн тӨрийн мэдлийн ногдол хувийг худалдах тухай журам

Нэг. Нийтлэг Үндэслэл

Монгол Улсын Засгийн газрын 1997 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан хувьчлагдах аж ахуйн нэгжүүдийн 1, 2 дугаар жагсаалтад заасан төрийн өмчийн оролцоотой хязгаарлагдмал хариуцлагатай компанийн (цаашид “компани” гэх) төрийн мэдлийн ногдол хувийг худалдахад Монгол Улсын “Нөхөрлөл компанийн тухай хууль”-ийн 91 дүгээр зүйл болон энэхүү журмыг баримтална.

Хоёр. Ногдол хувь худалдаж авах давуу эрх

Төр өөрийн мэдлийн ногдол хувийг худалдах тохиолдолд төрийн өмчийн оролцоотой хязгаарлагдмал хариуцлагатай компанийн төрийн мэдлээс бусад ногдол хувийг эзэмшигч Монгол Улсын болон гадаадын иргэн, хуулийн этгээд, харъяалалгүй хүн нь төрийн мэдлийн ногдол хувийг тэргүүн ээлжинд худалдан авах давуу эрхтэй.

Гурав. Ногдол хувь худалдаж авах эрх олж авах

1. Төр өөрийн мэдлийн ногдол хувийг тэргүүн ээлжинд төрийн өмчийн оролцоотой хязгаарлагдмал хариуцлагатай компанийн төрөөс бусад гишүүдэд худалдаж авахыг санал болгоно.

2. Төрийн өмчийн хороо нь төрийн өмчийн оролцоотой хязгаарлагдмал хариуцлагатай компанийн төрийн мэдлийн ногдол хувийг худалдах үнийг тогтоож, тухайн компанийн төрийн мэдлээс бусад ногдол хувийг эзэмшигч гишүүдэд худалдан авахыг санал болгох тухай шийдвэр гаргах бөгөөд энэхүү шийдвэрийн нэг хувь болон Төрийн өмчийн хорооны 1997 оны 807 дугаар тогтоолын 14 дүгээр хавсралтаар батлагдсан «Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн ногдол хувь эзэмшигчдэд төрийн мэдлийн ногдол хувийг худалдах, худалдан авах саналын хуудас»-ын (цаашид «саналын хуудас» гэх) хамт тухайн компанийн удирдлагад албан ёсоор хүлээлгэн өгнө.
3. Төр өөрийн мэдлийн ногдол хувийг нэг багц болгон тухайн компанид санал болгоно.
4. Төрийн өмчийн оролцоотой хязгаарлагдмал хариуцлагатай компани нь Төрийн өмчийн хорооны тогтоолын нэг хувийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 7 (долоо) хоногийн дотор төрийн мэдлийн ногдол хувийг худалдаж авах эсэх тухай саналаа албан бичгээр Төрийн өмчийн хороонд ирүүлнэ.
5. Төрийн өмчийн оролцоотой хязгаарлагдмал хариуцлагатай компанийн төрөөс бусад гишүүд нь төрийн мэдлийн ногдол хувийг худалдаж авахыг зөвшөөрсөн тохиолдолд төрийн өмчийн хорооноос санал болгосон үнийн дүнгийн 10 хувьтай тэнцэх дэнчинг ногдол хувь худалдаж авах санал гаргасан өдрөөс хойш ажлын 3 (гурван) өдрийн дотор Төрийн өмчийн хорооны дансанд төлснөөр тухайн ногдол хувийг худалдан авах эрх олж авна.

Дөрөв. Гэрээ байгуулах

1. Төрийн мэдлийн ногдол хувийг худалдан авахыг зөвшөөрсөн саналаа ирүүлсэн төрийн өмчийн оролцоотой хязгаарлагдмал хариуцлагатай компанийн төрд байгаагаас бусад ногдол хувь эзэмшигч этгээд буюу тэдгээрийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Төрийн өмчийн хороо буюу түүнээс эрх олгосон байгууллагатай Монгол Улсын “Иргэний хууль”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-д заасны дагуу төрийн мэдлийн ногдол хувь худалдах, худалдан авах гэрээг ногдол хувь худалдаж авах санал гаргасан өдрөөс хойш ажлын 3 (гурван) өдрийн дотор байгуулна.
2. Гэрээнд дор дурдсан зүйлийг заавал тусгана. Үүнд:
 - 1)худалдагдаж буй ногдол хувийн хэмжээ;
 - 2)худалдах үнэ;
 - 3)тавьсан дэнчингийн хэмжээ;
 - 4)үнэ төлөх хэлбэр;
 - 5)гэрээнд заасан үүргийг биелүүлээгүй буюу цаг тухайд нь биелүүлээгүйгээс үүсэх

хохирлыг нөхөн төлөх үндэслэл, журам, хэмжээ;

б)гэрээний үүргийн талаар үүссэн маргааныг хянан шийдвэрлэх журам.

Тав. Санал болгож худалдах ногдол хувь худалдан авагчдын эрх, үүрэг

1. Төрийн өмчийн хорооноос төрийн мэдлийн ногдол хувийг худалдаж авахыг санал болгосон этгээд нь дараах эрхтэй:

1)төрийн мэдлийн ногдол хувийг худалдан авах;

2)төрийн мэдлийн ногдол хувийг худалдаж авахаас татгалзах;

3)ногдол хувь худалдаж авахтай холбогдсон гомдлоо Төрийн өмчийн хороо, шүүхэд гаргах;

4)ногдол хувь худалдан авах эрхээ бусад гишүүддээ шилжүүлэх.

2. Төрийн өмчийн хорооноос санал болгосон ногдол хувийг худалдан авах тухай хүсэлтээ гаргасан этгээд дараах үүрэгтэй:

1)санал болгосон ногдол хувийг худалдаж авах эсэх талаарх шийдвэрээ энэ журамд заасан хугацаанд Төрийн өмчийн хороонд ирүүлэх;

2)тогтоосон хугацаанд дэнчинг төлөх;

3)худалдах, худалдан авах гэрээг тогтоосон хугацаанд байгуулах;

4)ногдол хувийн үнийг худалдах, худалдан авах гэрээ байгуулсан өдрөөс хойш хуанлийн 30 (гуч) хоногийн дотор бүрэн төлж, төлбөрийн баримтыг компанийн гишүүдийн хурлын шийдвэр, саналын хуудасны хамт Төрийн өмчийн хорооны Өмч хувьчлалын газар ирүүлнэ.

Зургаа. Төрийн мэдлийн ногдол хувийг эзэмших эрхийг шилжүүлэх

1. Худалдах, худалдан авах гэрээнд заасан хугацаанд ногдол хувийн төлбөрийг

бүрэн төлсөн тухайн компанийн төрөөс бусад гишүүдэд төрийн мэдлийн ногдол хувийг эзэмших эрхийг шилжүүлэх асуудлыг Төрийн өмчийн хорооны хурлаар хэлэлцэн шийдвэрлэж, шийдвэрийн хувийг шинэ өмчлөгч болон тухайн компанид хүргүүлнэ.

2. Дээрх шийдвэрийг үндэслэн хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрэм, гэрчилгээнд өөрчлөлт оруулах асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх асуудлыг тухайн компани хариуцна.

Долоо. Санал болгож худалдах ногдол хувийг дуудлагын худалдаагаар худалдах

1. Худалдан авагч нь ногдол хувийн үнийг худалдах, худалдан авах гэрээнд заасан хугацаанд төлөөгүй буюу бүрэн бус төлсөн бол дэнчинг улсын төсвийн орлого болгоно.

2. Төрийн өмчийн хороо дор дурдсан тохиолдолд төрийн өмчийн оролцоотой хязгаарлагдмал хариуцлагатай компанийн төрийн мэдлийн ногдол хувийг нийтийн (битүүмжилсэн) дуудлагын худалдаагаар худалдах тухай шийдвэр гаргана. Үүнд:

1)Төрийн өмчийн хорооноос тухайн компанийн төрөөс бусад гишүүдэд төрийн мэдлийн ногдол хувийг худалдан авахыг санал болгож тэдгээр бусад гишүүд нь уг ногдол хувийг худалдаж авахаас татгалзсан санал ирүүлсэн бол;

2)Тухайн компанийн ногдол хувь эзэмшигч төрөөс бусад гишүүд нь төрийн мэдлийн ногдол хувийг худалдаж авах тухай саналаа Төрийн өмчийн хороонд гаргах ёстой хугацаандаа ирүүлээгүй тохиолдолд санал болгосон ногдол хувийг худалдан авахаас татгалзаж байгаа гэж үзэж;

3)Дэнчинг энэ журамд заасан хугацаанд тавиагүй бол;

4)Худалдан авагч нь ногдол хувийн үнийг гэрээнд заасан хугацаанд төлөөгүй буюу бүрэн бус төлсөн бол.

3. Төрийн мэдлийн ногдол хувийг дуудлагын худалдаагаар худалдахдаа “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”, Төрийн өмчийн хорооны 1997 оны 308, 671, 833 дугаар тогтоолуудаар батлагдсан “Нийтийн дуудлагын худалдааг зохион байгуулж явуулах журам”, “Битүүмжилсэн дуудлагын худалдаа явуулах журам”, “Орон нутаг дахь төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийг дуудлагаар худалдах журам”-ын дагуу зохион байгуулж явуулна.

Найм. Маргаан шийдвэрлэх

Санал болгож худалдах ногдол хувийг худалдах явцад үүссэн маргааныг Төрийн өмчийн хороо шийдвэрлэнэ. Төрийн өмчийн хорооны шийдвэрийг зөвшөөрөхгүй тохиолдолд шүүхэд хандаж болно.

Ес. Бусад зүйл

Санал болгож худалдах ногдол хувь худалдахад тавих дэнчингийн хэмжээг өөрчлөх асуудлыг Төрийн өмчийн хороо шийдвэрлэнэ.